

**“ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН
ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал, Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар соёрхон баталсан.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа тамхины онцгой албан татварын асуудал, тамхины хэрэглээнд хяналт тавих, хэлэлцээрийн биелэлтэд гурван жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, үнэлгээний тайланг Улсын Их Хуралд танилцуулах “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулж, батлуулах санал гаргасныг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул тухайн хуулийг хэлэлцэн баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дэх дэд заалтад тамхи агуулсан янжуур болон бусад тамхины гаалийн тарифыг тэглэсэнтэй холбогдуулан нийтийн эрүүл мэнд, эдийн засаг, улсын төсөв, татварт нөлөөлөх үр дагаврын дүн шинжилгээ хийх, тамхины гаалийн тарифыг нөхөх, тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлэх тооцооллыг хийж, холбогдох хууль тогтоомжийн төслийг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, 2 дахь дэд заалтад Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатанд байгаа Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдан хэрэгжиж эхлэх хүртэлх хугацаанд тамхи, тамхин бүтээгдэхүүн, электрон тамхины импортын хэмжээг 2024 оны сар болгоны хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар хязгаарлах, 3 дахь дэд заалтад хэлэлцээрийн биелэлтэд хоёр жил тутамд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж, үнэлгээний тайланг Монгол Улсын Их Хуралд танилцуулахаар тусгасан.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороогоор хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир тогтоолын төсөлд тусгасан нэр томъёоны талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн тогтоолд тусгасан гаалийн тариф, онцгой албан татвартай холбогдуулан тооцоолол хийсэн эсэх, тамхины хэрэглээг хязгаарлахтай холбоотойгоор нийгэмд сөрөг үр дагавар үүсэх эрсдэлийг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг тогтоолын төслийг агуулгын хувьд дэмжиж байгаагаа илэрхийлээд, хэлэлцээрийн биелэлтэд гурван жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхээр тогтоолын төсөлд тусгасныг хоёр жил тутамд хэрэгжилтийн үр

дагаврын үнэлгээ хийхээр тусгах боломжтой эсэх талаар асуулт асууж, санал хэлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр батлах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



Д.ЭНХТҮВШИН

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай:

1/худалдааны түр хэлэлцээрээр тамхи агуулсан янжуур болон бусад тамхины гаалийн тарифыг тэглэсэнтэй холбогдуулан нийтийн эрүүл мэнд, эдийн засаг, улсын төсөв, татварт нөлөөлөх үр дагаврын дүн шинжилгээ хийх, тамхины гаалийн тарифыг нөхөх, тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлэх тооцооллыг хийж, холбогдох хууль тогтоомжийн төслийг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Монгол Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатанд байгаа Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдаж, хэрэгжиж эхлэх хүртэлх хугацаанд Гаалийн тухай хуулийн 8.1-д заасны дагуу тамхи, тамхин бүтээгдэхүүн, электрон тамхины импортын хэмжээг 2024 оны сар болгоны хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар хязгаарлах;

3/хэлэлцээрийн биелэлтэд хоёр жил тутамд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж, үнэлгээний тайланг Монгол Улсын Их Хуралд танилцуулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /Г.Тэмүүлэн/, Төсвийн байнгын хороо /Н.Наранбаатар/, Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд тус тус даалгасугай.

Гарын үсэг